



“ЭРДЭНЭС-ТАВАН ТОЛГОЙ” ХК

**Тендер
шалгаруулалт
гэрээний нэр:**

**ТОУАТА МАРКИЙН АВТО МАШИНЫ СЭЛБЭГ
НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Тендер
шалгаруулалт
гэрээний дугаар:**

ЭТТ/202001114

УЛААНБААТАР ХОТ

2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Эрдэнэс-Таван толгой” ХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Toyota** маркийн **авто машины сэлбэг** нийлүүлэх тухай цахим тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авч болно.

Үнийн саналыг 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө www.tender.gov.mn хаягаар илгээх ба үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 04 дүгээр сарын 29 – ний өдрийн 11 цаг 00 минутад нээнэ.

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8,
Финанс төв 5 давхар, 503 тоот, Улаанбаатар-15160,
Утас: 75055555-508**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь *ТШӨХ-д* заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 2. Татварын цахим тодорхойлолт ирүүлэх /тендер нээсэн өдрийн байдлаар өр төлбөргүй байх /. 3. 2019 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт хамт. 4. 2018, 2019 онуудын аль нэг жилд хийж гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлж байсан тухай гэрээ болон гэрээ дүгнэсэн акт эсхүл бараа хүлээлцсэн акт, харилцагчийн тодорхойлолт. 5. Иргэний хэргийн шүүхийн тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойших байдлаар/ 6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойших байдлаар/ 7. Нийлүүлэх сэлбэгийн албан ёсны гэрээт борлуулагчаар ажилладаг болохыг нотлох баримт ирүүлэх /Баталгаат орчуулгын хамт/ 8. Тендерт санал болгосон хугацаанд барааг нийлүүлээгүй тохиолдолд захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлэх. 9. Ашиглалтаас бус үйлдвэрлэгчээс гарсан эвдрэл гэмтэл эд анги нь захиалсан техникт таарахгүй, сэлбэгийн дугаар зөрсөн, үйлдвэрийн болон механик ямар нэгэн гэмтэл согогтой тохиолдолд таарах сэлбэг, эд ангиар сольж өгөх, баталгаат хугацаанд нийлүүлэгч бүрэн хариуцах талаар албан бичиг ирүүлэх. 10. Сэлбэг хэрэгсэл угсарч суурьлуулах засварын төвтэй байх./нотлох баримт ирүүлэх/ 11. Барааг угсарч, суурилуулах үйлчилгээний төлбөр багтсан гэдгийг албан бичгээр ирүүлэх. Мөн шаардлагатай үед худалдаж авах сэлбэгийн зардалд тусгасан 1.000.000 төгрөгийг үнийн саналд тооцож ирүүлэх гэдгийг анхаарах.
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа: Төрийн худалдан авах ажиллаганы цахим систем болох www.tender.gov.mn хаягаар цахимаар илгээнэ. Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 29 -ний өдөр Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8, Финанс төв. “Эрдэнэс-Таван Толгой” ХК, Улаанбаатар-15160 Давхар болон өрөөний дугаар: 5 давхар, 503 тоот Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 29 -ний өдөр Цаг: 11 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:

Land-200 МАРКИЙН АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Үндсэн шаардлага:

- ✓ Захиалагчид нийлүүлэх сэлбэг хэрэгслэл нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй байна.
- ✓ Нийлүүлэгдэх сэлбэг, эд анги нь захиалагчын гаргасан захиалгийн, тоо ширхэгт үндэслэн гүйцэтгэлээр нийлүүлэгдэнэ.
- ✓ Нийлүүлэгч нь сэлбэг эд ангийг хүснэгт 1-т заагдсан **Land-200** маркийн автомашины арлын дугаар, үндсэн үзүүлэлтүүдээр, хавсралт 1-т заагдсан сэлбэгийн дугаараар шалгаж таарах сэлбэгийн баталгаа ирүүлнэ.
- ✓ Хавсралт 1-т заагдсан сэлбэгийн жагсаалтаас гадна тус автомашины бүх төрлийн сэлбэг, эд ангийг нийлүүлэх чадамжтай байна.
- ✓ Хавсралт 1-т тусгагдаагүй сэлбэг, эд анги худалдан авах шаардлага үүссэн тохиолдолд захиалагчийн хүсэлтээр шаардлагатай сэлбэгийн жагсаалтыг гарган гэрээнд (хавсралт 2,3 г.м) нэмэлт өөрчлөлт оруулах ба нийлүүлэгч компани тухайн сэлбэгийг зах зээлийн дундаж ханшаар нийлүүлнэ.
- ✓ Нийлүүлэгдэх сэлбэг, эд анги нь техникт таарахгүй (Сэлбэгийн дугаар зөрсөн) тохиолдолд нийлүүлэгч бүрэн хариуцаж таарах сэлбэг, эд ангиар сольж өгөх үүрэг хүлээнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ:

Land cruiser 200 маркийн автобусны сэлбэг, эд анги доорх (хүснэгт-1)-т заагдсан үндсэн үзүүлэлт, сэлбэгийн дугаар, хөдөлгүүрийн загвар, сериалын дагуу шалгаж баталгаажуулсан, тухайн үйлдвэрлэгчийн албан ёсны борлуулагч байх шаардлагатай.

Land cruiser 200 маркийн автомашины үзүүлэлт

/Хүснэгт 1/

№	Модель	Үйлдвэрлэсэн он	Улсын дугаар	Арлын дугаар
1	Land -200	2014	23-97 УНИ	JTMHX05J504068741

Land cruiser 200 маркийн автомашинд шаардлагатай сэлбэг, хэрэгслэли жагсаалт:

хавсралт - 1.

№	Сэлбэгийн нэр	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ
1	Ламп /их гэрэл/	Ш	2
2	Ламп /ойрын гэрэл/	Ш	2
3	Ламп Номерийн гэрэл	Ш	2
4	Ламп /тоормозны гэрэл/	Ш	2
5	Урд өндгөн тулгуур 2ш	Ком	1
6	Хойд наклад	Ком	1
7	Урд наклад	Ком	1
8	Аккумулятор	Ш	1
9	Хойд амартизатор	Ш	2
10	Урд амартизатор	Ш	2
11	Хойд пүрш	Ш	2
12	Урд пүрш	Ш	2
13	Тэнхлэг тохиргоо	Ш	1
14	Свеча	Ш	4
15	Кадушка	Ш	8
16	Ступц	Ш	2
17	Плянз	Ш	4
18	Джинамны ремен	Ш	1
19	Хөндлөн тяг	Ш	2
20	Джинам	Ш	1
21	Форсунк цэвэрлэгч	Ш	1
22	Шарнер	Ш	1
23	Перда диск	Ш	1
24	Ган диск	Ш	1
25	Махвикны шарик	Ш	1
26	Шаардлагатай үед худалдаж авах Бусад /сэлбэг/		1000 000

Land cruiser 200 /шинэ/ МАРКИЙН АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Үндсэн шаардлага:

- ✓ Захиалагчид нийлүүлэх сэлбэг хэрэгслэл нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй байна. Нийлүүлэгдэх сэлбэг, эд анги нь захиалагчийн гаргасан захиалгийн, тоо ширхэгт үндэслэн гүйцэтгэлээр нийлүүлэгдэнэ.
- ✓ Нийлүүлэгч нь сэлбэг эд ангийг хүснэгт 2-т заагдсан **Ланд 200** маркийн автомашины арлын дугаар, үндсэн үзүүлэлтүүдээр, хавсралтад бичигдсэн сэлбэгийн дугаараар шалгаж таарах сэлбэгийн баталгаа ирүүлнэ.
- ✓ Хавсралтаар заагдсан сэлбэгийн жагсаалтаас гадна тус автомашины бүх төрлийн сэлбэг, эд ангийг нийлүүлэх чадамжтай байна.
- ✓ Хавсралтаар тусгагдаагүй сэлбэг, эд анги худалдан авах шаардлага үүссэн тохиолдолд захиалагчийн хүсэлтээр шаардлагатай сэлбэгийн жагсаалтыг гарган гэрээнд (хавсралт 2,3 г.м) нэмэлт оруулах ба нийлүүлэгч компани тухайн сэлбэгийг зах зээлийн дундаж ханшаар нийлүүлнэ.
- ✓ Нийлүүлэгдэх сэлбэг, эд анги нь техникт таарахгүй (Сэлбэгийн дугаар зөрсөн) тохиолдолд нийлүүлэгч бүрэн хариуцаж таарах сэлбэг, эд ангиар сольж өгөх үүрэг хүлээнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ:

Land cruiser 200 /шинэ / Toyota маркийн авто машины сэлбэг, эд анги нь хүснэгт 2- т заагдсан үндсэн үзүүлэлт, сэлбэгийн дугаар, хөдөлгүүрийн загвар, сериалын дагуу шалгаж баталгаажуулсан, тухайн үйлдвэрлэгчийн албан ёсны гэрээт борлуулагч байх шаардлагатай.

Land cruiser 200 /шинэ/ маркийн автомашины үзүүлэлт

/Хүснэгт 2/

№	Модель	Үйлдвэрлэсэн он	Улсын дугаар	Арлын дугаар
1	Land cruiser 200	2018 он	71- 47 УБД	JTMHV01J504259684

Land cruiser 200 маркийн автомашинд шаардлагатай сэлбэг, хэрэгслэлийн жагсаалт:

Хавсралт 1.

№	Сэлбэгийн нэр	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ
1	Хойд наклад	ком	1
2	Хойд амортизатор	ш	2
3	Урд амаортизатор	ш	2
4	Хойд пүрш	ш	2
5	Урд пүрш	ш	2
6	Втулк /саран гарны /	ш	2
7	Урд 4ш, хйод 4ш цапны шарик	ком	1
8	Дээд өндгөн тулгуур	ш	2
9	Шаардлагатай үед худалдаж авах бусад сэлбэг		1.000.000

LEXUS-LX470 МАРКИЙН АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Үндсэн шаардлага:

- ✓ Захиалагчид нийлүүлэх сэлбэг хэрэгслэл нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй байна.
- ✓ Нийлүүлэгдэх сэлбэг, эд анги нь захиалагчын гаргасан захиалгийн, тоо ширхэгт үндэслэн гүйцэтгэлээр нийлүүлэгдэнэ.
- ✓ Нийлүүлэгч сэлбэг эд ангийг хүснэгт 3 -т заагдсан **LEXUS-LX470** маркийн автомашины арлын дугаар, үндсэн үзүүлэлтүүдээр, хавсралт 1-т заагдсан сэлбэгийн дугаараар шалгаж таарах сэлбэгийн баталгаа ирүүлнэ.
- ✓ Хавсралтаар заагдсан сэлбэгийн жагсаалтаас гадна тус автомашины бүх төрлийн сэлбэг, эд ангийг нийлүүлэх чадамжтай байна.
- ✓ Хавсралтаар тусгагдаагүй сэлбэг, эд анги худалдан авах шаардлага үүссэн тохиолдолд захиалагчийн хүсэлтээр шаардлагатай сэлбэгийн жагсаалтыг гарган гэрээнд (хавсралт 2,3 г.м) нэмэлт өөрчлөлт оруулах ба нийлүүлэгч компани тухайн сэлбэгийг зах зээлийн дундаж ханшаар нийлүүлнэ.
- ✓ Нийлүүлэгдэх сэлбэг, эд анги нь техникт таарахгүй (Сэлбэгийн дугаар зөрсөн) тохиолдолд нийлүүлэгч бүрэн хариуцаж таарах сэлбэг, эд ангиар сольж өгөх үүрэг хүлээнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ:

LEXUS-LX470 маркийн авто машины сэлбэг, эд анги доорх (хүснэгт-3)-т заагдсан үндсэн үзүүлэлт, сэлбэгийн дугаар, хөдөлгүүрийн загвар, сериалын дагуу шалгаж баталгаажуулсан, тухайн үйлдвэрлэгчийн албан ёсны борлуулагч байх шаардлагатай.

LEXUS-LX470 маркийн автомашины үзүүлэлт

/Хүснэгт 3/

№	Модель	Үйлдвэрлэсэн он	Улсын дугаар	Арлын дугаар
1	LEXUS-LX470	2007 он	55-98 УБҮ	JTJHM00W064019451

LEXUS-LX470 маркийн автомашинд шаардлагатай сэлбэг, хэрэгслэлийн жагсаалт:

Хавсралт 1.

№	Сэлбэгийн нэр	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ
1	Ламп /их гэрэл/	ш	2
2	Ламп /ойрын гэрэл/	ш	2
3	Ламп /тооромзны гэрэл/	ш	2
4	Кууперийн нэмэгдэл гэрэл ламп	ш	2
5	Шил арчигчийн резин	ш	4
6	Хойд өндгөн тулгуур 2ш	ком	1
7	Рулийн аппарат	ком	1
8	5 бул 4ш	ш	4
9	Хойд босоо тэнцүүлэгч	хос	2
10	Урд босоо тэнцүүлэгч	хос	1
11	Урд плянз	ш	2
12	Хойд дэр резин 4ш	ком	5
13	Урд дэр резин 4ш	ком	4
14	Форсунг цэвэрлэгч	ш	1
15	Хөндлөн тяг	ш	1
16	Хойд наклад	ком	1
17	Хойд амортизатор	ш	2
18	Урд амортизатор	ш	2
19	Хойд пүрш	ш	2
20	Урд пүрш	ш	2
21	Аккумулятор	ш	1
22	Свеча	ш	8
23	катушки	ш	8
24	Кузов өргөгч насос	ш	1
25	Шаардлагатай үед худалдаж авах бусад / сэлбэг /		1.000.000

LEXUS-570 МАРКИЙН АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Үндсэн шаардлага:

- ✓ Захиалагчид нийлүүлэх сэлбэг хэрэгслэл нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй байна. Нийлүүлэгдэх сэлбэг, эд анги нь захиалагчийн гаргасан захиалгийн, тоо ширхэгт үндэслэн гүйцэтгэлээр нийлүүлэгдэнэ.
- ✓ Нийлүүлэгч нь сэлбэг эд ангийг хүснэгт 4-т заагдсан **LEXUS-570** маркийн автомашины арлын дугаар, үндсэн үзүүлэлтүүдээр, хавсралт 1-т заагдсан сэлбэгийн дугаараар шалгаж таарах сэлбэгийн баталгаа ирүүлнэ.
- ✓ Хавсралтад заагдсан сэлбэгийн жагсаалтаас гадна тус автомашины бүх төрлийн сэлбэг, эд ангийг нийлүүлэх чадамжтай байна.
- ✓ Хавсралтад тусгагдаагүй сэлбэг, эд анги худалдан авах шаардлага үүссэн тохиолдолд захиалагчийн хүсэлтээр шаардлагатай сэлбэгийн жагсаалтыг гарган гэрээнд (хавсралт 2,3 г.м) нэмэлт оруулах ба нийлүүлэгч компани тухайн сэлбэгийг зах зээлийн дундаж ханшаар нийлүүлнэ.
- ✓ Нийлүүлэгдэх сэлбэг, эд анги нь техникт таарахгүй (Сэлбэгийн дугаар зөрсөн) тохиолдолд нийлүүлэгч бүрэн хариуцаж таарах сэлбэг, эд ангиар сольж өгөх үүрэг хүлээнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ:

LEXUS-570 маркийн автобусны сэлбэг, эд анги доорх (хүснэгт-4)-т заагдсан үндсэн үзүүлэлт, сэлбэгийн дугаар, хөдөлгүүрийн загвар, сериалын дагуу шалгаж баталгаажуулсан, тухайн үйлдвэрлэгчийн албан ёсны борлуулагч байх шаардлагатай.

LEXUS 570 маркийн автомашины үзүүлэлт

/Хүснэгт 4/

№	Модель	Үйлдвэрлэсэн он	Улсын дугаар	Арлын дугаар
1	LEXUS-570	2013 он	52-28 УНС	JTJHY7AX4D4102806

LEXUS-570 маркийн автомашинд шаардлагатай сэлбэг, хэрэгслэлийн жагсаалт:

Хавсралт 1.

№	Сэлбэгийн нэр	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ
1	Рулийн аппарат	ш	1
2	Таван бул 4	ком	1
3	Хойд наклад	ком	2
4	Урд наклад	ком	2
5	Куков өргөгч насос	ш	1
6	Тэнхлэг тохиргоо	ш	1
7	Дээд өндгөн тулгуур	ш	1
8	Доод өндгөн тулгуур	ш	1
9	Ламп /их гэрэл/	ш	2
10	Ламп /ойрын гэрэл/	ш	2
11	Ламп /жижиг гэрэл/	ш	2
12	Ламп /гуперийн нэмэгдэл гэрэл/	ш	2
13	Бусад		-

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

№	Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						Нийлүүлэлтийн эхний хугацаа	Нийлүүлэлтийн эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	Toyota маркийн авто машин	Техникийн тодорхойлолтод тусгасан сэлбэг, хэрэгсэл, эд анги	Техникийн тодорхойлолтод тусгасан тоо ширхэг	Техникийн тодорхойлолтод тусгасан хэмжих нэгжээр	“Эрдэнэс-Таван Толгой” ХК-ийн Төв оффисын байр	Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 15 - 45 хоногийн дотор	Гүйцэтгэлээр 1 жил хүртэл хугацаанд	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлд заасны дагуу барааг хүлээн авах үед Захиалагч талыг төлөөлж захиалагчийн сонгосон эрх бүхий этгээд барааг шалгаж хүлээн авна. Барааг шалгахтай холбоотой бүхий л зардлыг Гүйцэтгэгч тал хариуцна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:

1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
2) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Гүйцэтгэгч тал нь нийлүүлж буй бараанд 1 жилээс доошгүй баталгаат засварын хугацаа гаргаж өгнө. |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | Төлбөрийг ажлын гүйцэтгэлээр буюу Захиалагчийн гаргасан захиалгын дагуу нэхэмжлэл, сэлбэгийг нийлүүлсэн болон хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн барааг нийлүүлснээс хойш ажлын 10 хоногт төлбөрийг төлнө. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9) ¹ | 9.1. Алданги ноогдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дүнгийн [0.5%] байна

Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн [10 хувь] байна. |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]